

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Аудитын гэрчилгээ	1
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.9.1 Авлага.....	8
2.9.2 Урьдчилгаа	10
2.9.3 Өр төлбөр	10
2.9.4 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.12. Шилэн дансны мэдээлэл	13
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал.....	15
3.1 Авлагатай холбоотой асуудал.....	15
3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР ТАНАА

2020.03.25 № 01/938
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан болон харьяа байгууллагуудын олгосон жижиг зээл, санхүүгийн дэмжлэгээс 25,304.8 сая төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;
- ХЭДС санхүүгийн тайланд тусгасан хөтөлбөртэй холбоотой 657.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Сангийн хөрөнгөөр худалдан авсан 16.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн бүртгэлд шилжүүлэн тусгаагүй;
- Сангийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан 28.9 сая төгрөгийн ном, гарын авлага худалдан авсан, сургалтын зардлууд баримтаар нотлогдоогүй;
- Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний дагуу 50.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй багаж, тоног төхөөрөмжөөр үзүүлэх дэмжлэгийг бэлэн мөнгөөр үзүүлсэн

зэрэг нь үнэн зөв, тохиолдсон байх, эрх үүрэг, иж бүрэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дүгээр зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ө.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Бадрахбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 09-нөөс 2020 оны 3 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Г.Түвшинзаяа гүйцэтгэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 1/373 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа буюу хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлдэг сан юм.

Эрхэм зорилго:

Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны соёл төлөвшүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлж, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшинг бууруулах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.
- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу 2019 оны 12 дугаар сард шинэчлэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газраас 2019 онд Багануур, Хан-Уул, Баянгол дүүрэг, Өвөрхангай, Архангай, Ховд, Увс, Орхон, Баянхонгор, Завхан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 5 зөвлөмж өгсөн ба өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн байдлын мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 152,493.9 сая төгрөгийн 1 хувь буюу 1,524.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 30 байгууллага аудитад хамрагдаж, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 28 санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс “Зөрчилгүй” 17, “Хязгаарлалттай” 10 /Багануур, Багахангай, Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн хөдөлмөрийн газар, Говь-Алтай аймаг/, “Сөрөг” 1 /Баянзүрх дүүрэг/ болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 30,710.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 192.5 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 48,5 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20,778.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1,082.3 сая төгрөгийн зөрчилд албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулахаар санал хүргүүлж, 8,608.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 21 зөвлөмжийг хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн Капитал банктай холбоотой 1,300.0 сая, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой 15,819.9 сая төгрөгийн авлагын зээлийн төлөх хугацаа хэтэрсэн, үлдэгдлийг барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.12-т "Найдваргүй авлагыг бүртгэхдээ авлагыг хорогдуулах хэмжээ, баримтлах зарчим, нөхцөлийг заасан эрх бүхий байгууллагын найдваргүй болсон авлагыг данснаас хасах тухай шийдвэрийг үндэслэнэ. Шийдвэр гартал уг найдваргүй болсон авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

Анод банктай холбоотой 800.0 сая, Дэлгэр эксперс ХХК-тай холбоотой 47.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар албан шаардлага хүргүүлсэн ба аудитын явцад 47.4 сая төгрөгийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлж, барагдуулахаар болсон байна.

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөс 18 байгууллага, иргэдэд олгосон 1,870.3 сая төгрөгийн зээлийн гэрээнд заасан хугацаанд эргэн төлөлт хийгдээгүй нь Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийлүүлсэн зорилтот төслийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3-д "Б тал нийт олгогдох санхүүжилтийг гэрээгээр заасан хугацаанд 100 хувь эргүүлэн төлнө", 4.5-д "Энэхүү гэрээний 4.4 дэх заалтыг биелүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам 0.5 хувийн алданги тооцож А талд төлнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчид залруулагдаагүй зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

Харьяа байгууллагуудын алдаа, зөрчил

Харьяа байгууллагуудын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,345.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 145.1 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 48.5 сая төгрөгийн 8

зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,082.3 сая төгрөгийн зөрчилд албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар шилжүүлэн, 988.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлж, 3,081.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 20 зөвлөмжийг хүргүүлжээ.

Залруулагдаагүй алдаа зөрчлийг тайлангийн хавсралтад зөрчлийн нэгтгэлийн хүснэгтэд тусгав.

2.9. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 144,809.7 сая, эцсийн үлдэгдэл 186,633.4 сая төгрөг болж, 41,823.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 1 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	0.1	-0.1
Татаас, санхүүжилтийн авлага	47,261.4	96,656.4	49,395.0
Зээлийн хүүгийн авлага	-	56.9	56.9
Бусад авлага	4,117.0	3,915.0	-202.0
Зээлийн авлага	93,431.1	86,005.0	-7,426.1
Дүн	144,809.7	186,633.4	41,823.7

Эх сурвалж: ХЭДСангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татаас санхүүжилтийн авлага 96,656.4 сая төгрөг нь 2019 оны зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Зээлийн хүүгийн авлага 56.9 сая төгрөг нь Дэлхийн банкны төслийн 8,000.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Төрийн банк, Хаан банкаар дамжуулан зээлдүүлсэн хүүгийн авлага байна.

Бусад авлага 3,914.9 сая төгрөгийн үлдэгдэлд байгууллагаас авах 2,970.9 сая төгрөгийн зээлийн алданги, 737.0 сая төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрийн авлага, 139.3 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага, 47.4 сая төгрөгийн Дэлгэр экспресс ББСБ-тай холбоотой авлага, 20.3 сая төгрөгийн бусад авлага орж байна.

Хүснэгт № 2 Зээлийн авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Зээлийн төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Дотоод эх үүсвэрээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,819.9	39.3
Гадаад эх үүсвэрээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	8,000.0	9.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний дэмжих хөтөлбөр	12,886.4	15.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5,073.5	5.9
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	11,105.3	12.9
Засгийн газар, ХЭҮЗ бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	7,002.1	8.1

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	1,116.8	1.3
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	7001.0	8.1
Дүн	86,005.0	100.0

Дотоод эх үүсвэрээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлд Анод банкны 800.0 сая төгрөгийн зээл, Оёдлын нэгдсэн холбоонд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон 15,819.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, Капитал банкаар дамжуулсан 1,300.0 сая төгрөгийн зээл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Хаан банк 9,000.0 сая төгрөг, Төрийн банк 6,900.0 сая төгрөг олгосон зээл байна.

Гадаад эх үүсвэрээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлд Дэлхийн банкны төслөөс дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээний дагуу “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Төрийн банкаар 3,990.0 сая төгрөг, Хаан банкаар дамжуулан олгосон 4,010.0 сая төгрөгийн зээлийн авлага байна.

Зээлийн авлагын үлдэгдэлд олон жил болсон, зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 27,717.9 сая төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- 2013 онд Оёдлын нэгдсэн холбоонд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон 15,819.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, зээлийн алданги 2,694.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн барагдаагүй авлага;
- 2016 онд Капитал банктэй жижиг зээлийг санхүүжүүлэхээр хамтран ажилласан гэрээний үлдэгдэл 1,300.0 сая төгрөг, зээлийн алданги 265.6 сая төгрөгийн барагдаагүй авлага;
- 2015 онд татан буугдсан Анод банкны 800.0 сая төгрөгийн авлага;
- 2008 онд үүссэн Дэлгэр экспресс ББСБ-тай холбоотой 47.5 сая төгрөгийн авлага;
- 2015-2017 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжихэд олгосон 3.0-5.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 50-100 хувийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 2,296.2 сая төгрөгийн зээлийн авлага /Налайх дүүрэг 23.2 сая, Чингэлтэй дүүрэг 128.4 сая, Хан-Уул дүүрэг 56.6 сая, Сүхбаатар дүүрэг 62.4 сая, Сонгинохайрхан дүүрэг 114.0 сая, Баянзүрх дүүрэг 163.7 сая, Баянгол дүүрэг 115.8 сая, Багахангай дүүрэг 4.2 сая, Говьсүмбэр аймаг 1.6 сая, Орхон аймаг 39.8 сая, Дархан аймаг 66.0 сая, Хэнтий аймаг 99.1 сая, Хөвсгөл аймаг 202.1 сая, Ховд аймаг 251.3 сая, Увс аймаг 151.6 сая, Төв аймаг 15.8 сая, Сэлэнгэ аймаг 37.2 сая, Сүхбаатар аймаг 29.2 сая, Өмнөговь аймаг 68.9 сая, Өвөрхангай аймаг 6.2 сая, Завхан аймаг 181.4 сая, Дундговь аймаг 29.0 сая, Дорнод аймаг 110.7 сая, Дорноговь аймаг 114.7 сая, Говь-Алтай аймаг 3.1 сая, Булган аймаг 34.7 сая, Баянхонгор аймаг 92.4 сая, Баян-Өлгий аймаг 43.1 сая, Архангай аймаг 50.2 сая/;
- 2014-2017 онуудад малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу малжуулах арга хэмжээнд 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 50-100 хувийг 24-36 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 1,882.7 сая төгрөгийн зээлийн авлага /Налайх дүүрэг 12.7 сая, Багануур дүүрэг 9.5 сая, Говьсүмбэр аймаг 2.8 сая, Орхон аймаг 16.4 сая, Дархан аймаг 8.7 сая, Хэнтий аймаг 55.4 сая, Хөвсгөл аймаг 214.2 сая, Ховд аймаг 118.7 сая, Увс аймаг 188.9 сая, Төв аймаг 7.6 сая, Сэлэнгэ аймаг 52.1 сая, Сүхбаатар аймаг 27.1 сая, Өмнөговь аймаг 57.2 сая, Өвөрхангай аймаг 70.9 сая, Завхан аймаг 339.6 сая, Дундговь аймаг 28.9 сая, Дорнод аймаг 232.9 сая, Дорноговь аймаг 104.5 сая, Говь-Алтай аймаг 11.9 сая, Булган аймаг 17.5 сая, Баянхонгор аймаг 151.0 сая, Баян-Өлгий аймаг 55.8 сая, Архангай аймаг 74.6 сая/;
- 2017 онд Засгийн газар, ХЭҮЗ бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөрийн дагуу орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн зорилтот төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдэд олгосон 1,650.4 сая төгрөгийн зээлийн авлага (Энэхүү авлага нь 2020 онд барагдуулж дуусах шүүхийн шийдвэртэй);

- 2017 онд ахмад мэргэжилтэний зөвлөх үйлчилгээ хөтөлбөрийн дагуу ахмад иргэнд олгосон 3.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 100 хувийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 129.8 сая төгрөгийн зээлийн авлага / Налайх дүүрэг 2.7 сая, Чингэлтэй дүүрэг 12.0 сая, Хан-Уул дүүрэг 4.5 сая, Сүхбаатар дүүрэг 0.7 сая, Баянзүрх дүүрэг 9.8 сая, Баянгол дүүрэг 2.6 сая, Багануур дүүрэг 0.6 сая, Дархан аймаг 4.4 сая, Хэнтий аймаг 0.5 сая, Хөвсгөл аймаг 7.0 сая, Ховд аймаг 30.1 сая, Увс аймаг 19.0 сая, Сэлэнгэ аймаг 5.2 сая, Сүхбаатар аймаг 0.2 сая, Өмнөговь аймаг 1.0 сая, Өвөрхангай аймаг 0.1 сая, Завхан аймаг 2.5 сая, Дундговь аймаг 0.3 сая, Дорнод аймаг 8.0 сая, Булган аймаг 2.2 сая, Баянхонгор аймаг 4.5 сая, Баян-Өлгий аймаг 5.4 сая, Архангай аймаг 2.9 сая/;
- 2017 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн дагуу гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн 100 хувийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 681.8 сая төгрөгийн зээлийн авлага /Нийслэлийн хөдөлмөр эрхлэх газар 40 сая, Налайх дүүрэг 13.9 сая, Чингэлтэй дүүрэг 59.9 сая, Хан-Уул дүүрэг 10.4 сая, Сүхбаатар дүүрэг 1.7 сая, Сонгинохайрхан дүүрэг 63.8 сая, Баянзүрх дүүрэг 41.4 сая, Баянгол дүүрэг 71.7 сая, Багахангай дүүрэг 2.7 сая, Багануур дүүрэг 12.2 сая, Орхон аймаг 5.6 сая, Дархан аймаг 11.2 сая, Хэнтий аймаг 23.1 сая, Хөвсгөл аймаг 19.5 сая, Ховд аймаг 12.7 сая, Увс аймаг 36.6 сая, Сэлэнгэ аймаг 2.3 сая, Сүхбаатар аймаг 10.7 сая, Өмнөговь аймаг 9.9 сая, Өвөрхангай аймаг 23.3 сая, Завхан аймаг 45.5 сая, Дундговь аймаг 8.1 сая, Дорнод аймаг 65.1 сая, Говь-Алтай аймаг 2.3 сая, Булган аймаг 25.6 сая, Баянхонгор аймаг 19.2 сая, Баян-Өлгий аймаг 13.5 сая, Архангай аймаг 29.9 сая/;
- Бусад авлага 149.4 сая төгрөг

Аудитын илрүүлэлт:

- БНД-ийн ХЭДС 655.9 сая төгрөгийн авлагын дансны үлдэгдлийг харилцагч тус бүрээр кодолж санхүүгийн программд тусгаагүй,
- БЗД-ийн ХЭДС 781.7 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу олгоогүй, 61.0 сая төгрөгийн зээлийн гэрээг хуульд заасны дагуу байгуулаагүй зөрчилд өгсөн өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;
- БГД-ийн ХЭДС санхүүгийн тайланд тусгасан хөтөлбөртэй холбоотой 657.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

2.9.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 258.4 сая, эцсийн үлдэгдэл 35.8 сая төгрөг болж, 222.6 сая төгрөгөөр төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	258.4	35.8	-222.6
Дүн	258.4	35.8	-222.6

Эх сурвалж: ХЭДСангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 35.8 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- Говь-Алтай ХЭДС нь ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн бүлгийн зохион байгуулалттай арга хэмжээний зардалд худалдан авах ажиллагааны тендер зарлаж, гүйцэтгэлийн хугацаа нь он дамжин хэрэгжих болсон 12.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр;
- Дархан ХЭДС нь санхүүгийн дэмжлэгийн бүртгэл мэдээллийн систем ажиллуулах худалдан авах ажиллагааны тендер зарлаж, гүйцэтгэлийн хугацаа нь он дамжин хэрэгжих болсон тул 23.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр байна.

2.9.3 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 18,593.3 сая, эцсийн үлдэгдэл 30,543.5 сая төгрөг болж, 11,950.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	18,593.3	22,328.6	3,735.3	31.2
Урт хугацаат өр төлбөр дүн	-	8,214.9	8,214.9	68.8
Нийт дүн	18,593.3	30,543.5	11,950.2	100

Эх сурвалж: ХЭДСангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 7.7 сая төгрөгийн хувь хүмүүст олгосон зээл, 1.0 сая төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг, 34.1 сая төгрөгийн зээлийн хүүгийн өглөг, 63.2 сая төгрөгийн бусад өглөг, 22,222.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

Урьдчилж орсон 22,222.5 сая төгрөгийн орлого нь “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2020 оны зөвшөөрлийн урьдчилгаа төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2019 онд Сангийн яам, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын хооронд байгуулсан Дэлхийн банкны төслөөс дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээний дагуу “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл”-ийн санхүүжилт 8,000.0 сая төгрөгийн өр, ханшийн зөрүү 214.9 сая төгрөг нийт 8,214.9 сая төгрөгийн өр байна.

Аудитын илрүүлэлт:

- Өвөрхангай аймгийн ХЭДС хувь хүний орлогын албан татварын 2.0 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн;
- Нийслэлийн ХЭГ тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй он дамжсан 13.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй;
- Баян-Өлгий аймгийн ХЭДС Нийтийг хамарсан ажил, ахмадын зөвлөх үйлчилгээний хөлснөөс 1.8 сая төгрөгийн татварыг суутган ч татварт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй, хувь хүнээс худалдан авсан бараа, хяналтын урамшуулалд олгосон хөлснөөс 1.0 сая төгрөгийн татварыг суутгаагүй.

2.9.4 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 126,474.7 сая, эцсийн үлдэгдэл 156,125.6 сая төгрөг болж, 29,650.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Хуримтлагдсан үр дүн	126,474.7	156,125.6	29,650.9	100.0
Дүн	126,474.7	156,125.6	29,650.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харьяа байгууллагуудын тайлант үеийн үр дүн 29,582.7 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй, нягтлан бодох бүртгэлийн 68.2 сая төгрөгийн залруулга нь засгийн газрын оролцоо данс 29,650.9 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 6 хөтөлбөрт зориулан 83,382.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 28,500.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 40,836.4 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 14,046.0 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагджээ.

Нийт орлогын гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,100.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 58,128.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 44,113.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, гадаад эх үүсвэрээс 3,137.8 сая төгрөг нийт 114,479.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Сангийн яам тус сангийн үндсэн үйл ажиллагааны орлого болон төсвийн гүйцэтгэлийг хянан улсын төсвийн санхүүжилтийг 19,400.0 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 17,292.1 сая төгрөгөөр давсан нь “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр 2020 оноос 1 сарын хураамж 840,000.0 төгрөг болсон урьдчилгаа төлбөр төлөгдсөн, мөн Хөдөлмөрийн тухай хуульд “Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй тохиолдолд орон тоо тутамд сар бүр зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлнэ” гэж заасны дагуу 2019 онд МХЕГ-ын хяналт шалгалтын мөрөөр болон тус ерөнхий газрын харьяа салбар газар хэлтсүүд аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа гарган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй байгууллагуудыг төлбөр төлөх албан шаардлага өгч ажилласны үр дүн нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 55,575.0 сая төгрөг буюу 27,807.4 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Дутуу зарцуулсан төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг авч үзвэл:

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэтгэлэг 22,415.7 сая;
 - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ зардлаас 150.8 сая;
 - Ажилд зуучлах үйлчилгээ зардлаас 393.8 сая;
 - Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрөөс 244.6 сая;
 - Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 1,659.4 сая;
 - Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 672.7 сая;
 - Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 424.2 сая;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 477.3 сая;
 - Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрөөс 204.1 сая төгрөг
- тус тус дутуу зарцуулсан нь тухайн хөтөлбөр, сургалт, үйлчилгээнд төлөвлөснөөс бага хүн хамрагдсантай холбоотой байна.
- Дотоод үйл ажиллагааны зардлаас 1,143.3 сая;
 - ХЭҮЗөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зардлаас 21.4 сая төгрөгийг хэмнэсэн нь зардлын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 8,062.3 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 24.4 сая, нийт 8,086.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Төрийн банк, Хаан банкаар дамжуулан зээлдүүлэх эргэн төлөгдөх жижиг зээлд 8,000.0 сая, Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөрт 57.9 сая, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, сурталчилгаа, чадавх бэхжүүлэх хөтөлбөрт 28.7 сая, нийт 8,086.7 сая төгрөгийг зарцуулсан байна

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн ХЭДС сангийн хөтөлбөрт хамрагдах нийтийг хамарсан ажилд зарцуулах зардлын 10-15 хувийг хог хаягдал цэвэрлэгээний ажилд зарцуулахаас 12.4 сая төгрөгийг илүү зарцуулсан;
- БЗД ХЭДС сангийн үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн 28.9 сая төгрөгийн ном, гарын авлага, сургалтын зардлууд баримтаар нотлогдоогүй;
- Баян-Өлгий ХЭДС сангийн хөрөнгөөр худалдан авсан 16.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХҮГ-т шилжүүлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна;
- Баянхонгор аймгийн ХЭДС нь Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгаас төсвөөс 2017, 2018 онд олгосон санхүүжилтийн 7.2 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр, төв сангийн дансанд төвлөрүүлсэн;
- СБ аймаг ХЭДС Малжуулах арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг, туслалцааны зардлыг 7.5 сая төгрөгийг илүү зарцуулсан;
- Говь-Алтай аймгийн ХЭДС зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний дагуу 50.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй багаж, тоног төхөөрөмжөөр үзүүлэх дэмжлэгийг бэлэн мөнгөөр үзүүлсэн.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон жижиг зээл, түүнд батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийн сангийн ашиглалт, нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хийсэн дотоод хяналт шалгалтын үр дүн, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авсан эсэхэд дараагийн аудитаар авч үзэх хэрэгтэй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 26.7 сая төгрөгийн зөрчилд тогтоосон акт бүрэн барагдсан, 1,343.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 144.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, БЗД-ийн ХЭДС-д хүргүүлсэн 1,100.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжээгүй байна.

Нийт 38 зөвлөмж өгснөөс 38 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт

Залруулагдаагүй 25,304.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 1,524.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан болон түүний харьяа байгууллагууд жижиг зээл болон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.1.6 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах", Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 6 дахь Хяналт тавих, тайлагнах бүлэгт заасан заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, зээл олголт болон эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, найдваргүй зээл үүсгэхгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

ХХҮЕГ-ын Хяналт мониторингийн газраас 4 дүүрэг, 8 аймгийн ХЭДС-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн боловч, нийт зээлийн авлагын үлдэгдлийн 51.8 хувийг эзэлж байгаа ХЭД төв сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгээгүй, харьяа ХЭДС-уудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,345.1

сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Дотоод хяналтын үр нөлөөгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын төлөвлөгөөнд эрсдэл ихтэй байгаа үйл ажиллагааг эрэмбэлж, хяналт шалгалтыг зохион байгуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,068,112.4	186,669,162.7
33	АВЛАГА	144,809,678.4	186,633,375.7
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	224.0	145.3
33300	Татаас, санхүүжилтийн авлага	47,261,409.5	96,656,375.1
33400	Зээлийн хүүгийн авлага	-	56,929.3
33500	Бусад авлага	4,117,004.8	3,914,977.6
33510	Байгууллагаас авах авлага	3,078,328.5	3,032,942.4
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,038,676.3	882,035.2
33600	Зээлийн авлага	93,431,040.1	86,004,948.4
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	93,431,040.1	78,004,948.4
33612	Хувь хүмүүст олгосон зээл	34,261,118.8	44,185,027.1
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	59,169,921.2	33,819,921.3
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	8,000,000.0
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	-	8,000,000.0
34	УРЬДЧИЛГАА	258,434.0	35,787.1
34600	Урьдчилж гарсан зардал	258,434.0	35,787.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	145,068,112.4	186,669,162.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,593,326.0	30,543,518.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,593,326.0	22,328,582.5
41200	Богино хугацаат зээлийн өглөг	10,250.9	7,715.2
41210	Төгрөг	10,250.9	7,715.2
41212	Хувь хүмүүст олгосон зээл	10,250.9	7,715.2
41300	Өглөг	48,391.3	98,417.2
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,027.9	1,027.9
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	34,119.6
41360	Бусад өглөг	47,363.4	63,269.7
41361	Байгууллагад төлөх өглөг	33,836.1	49,873.7
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13,527.4	13,396.0
41400	Урьдчилж орсон орлого	18,534,683.8	22,222,450.1
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	18,534,683.8	22,222,450.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,214,935.6
42200	Урт хугацаат зээл	-	8,214,935.6
42210	Төгрөг	-	8,214,935.6
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	8,214,935.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	126,474,786.4	156,125,644.7
51	Засгийн газрын хувь оролцоо	126,474,786.4	156,125,644.7
51200	Хуримтлагдсан үр дүн	126,474,786.4	156,125,644.7
51210	Өмнөх үеийн үр дүн	111,536,385.3	126,542,960.5
51220	Тайлант үеийн үр дүн	14,938,401.1	29,582,684.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	145,068,112.4	186,669,162.7

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	28,984,534.1	63,677,026.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,034,534.1	54,452,582.1
120	Нийтлэг татварын бус орлого	25,034,534.1	54,452,582.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,034,534.1	54,452,582.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,896,714.1	50,695,889.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,699,763.7
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,137,820.0	-
1200046	Зээлийн хүүгийн орлого	-	56,929.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,950,000.0	9,224,444.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,850,000.0	9,100,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,850,000.0	9,100,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	24,444.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	24,444.5
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,000.0	100,000.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	100,000.0	100,000.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,046,132.9	33,879,406.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,046,132.9	33,879,406.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,800.1	263,250.7
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,220.0
210404	Ном, хэвлэл	-	23,220.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,800.1	205,268.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,800.1	205,268.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34,762.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	34,762.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,870,332.8	33,616,156.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,870,332.8	33,616,156.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,870,332.8	33,616,156.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	14,938,401.1	29,797,619.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	214,935.6
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	214,935.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	14,938,401.1	29,582,684.2

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	98,034,737.1	160,493,991.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,734,737.1	117,857,271.0
120	Нийтлэг татварын бус орлого	89,734,737.1	117,857,271.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,734,737.1	117,857,271.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,352,914.2	66,862,385.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,733,475.5
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	39,244,002.9	44,123,589.5
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,137,820.0	3,137,820.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,300,000.0	42,636,720.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,200,000.0	34,450,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,850,000.0	9,100,000.0
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	4,350,000.0	25,350,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,086,720.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,062,275.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	24,444.5
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,000.0	100,000.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	100,000.0	100,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,134,737.1	152,493,991.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,134,737.1	152,493,991.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,488.1	325,565.9
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,220.0
210404	Ном, хэвлэл	-	23,220.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,488.1	205,308.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	178,488.1	205,308.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	97,037.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	62,275.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	34,762.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,956,248.9	152,168,425.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,694,839.4	55,512,050.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,694,839.4	55,512,050.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,261,409.5	96,656,375.1
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,261,409.5	96,656,375.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,900,000.0	8,000,000.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-15,900,000.0	-8,000,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	15,900,000.0	8,000,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	15,900,000.0	8,000,000.0

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
1	2017 оны 12-р сарын 31- нээх үлдэгдэл	-	-	111,809,697.5	111,809,697.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-273,312.2	-273,312.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	111,536,385.3	111,536,385.3
4	Тайлант үеийн үр дүн	-	-	14,938,401.1	14,938,401.1
5	2018 оны 12-р сарын 31- нээх үлдэгдэл	-	-	126,474,786.4	126,474,786.4
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	68,174.1	68,174.1
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	126,542,960.5	126,542,960.5
8	Тайлант үеийн үр дүн	-	-	29,582,684.2	29,582,684.2
9	2019 оны 12-р сарын 31- нээх үлдэгдэл	-	-	156,125,644.7	156,125,644.7

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,382,403.0	55,575,013.3	27,807,389.7	33.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,382,403.0	55,575,013.3	27,807,389.7	33.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000.0	176,570.4	21,429.6	10.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000.0	176,570.4	21,429.6	10.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.0	176,570.4	21,429.6	10.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,184,403.0	55,398,442.9	27,785,960.1	33.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,184,403.0	55,398,442.9	27,785,960.1	33.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,184,403.0	55,398,442.9	27,785,960.1	33.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,382,403.0	111,437,641.1	-28,055,238.1	-33.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,500,000.0	9,100,000.0	19,400,000.0	68.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	28,500,000.0	9,100,000.0	19,400,000.0	68.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	54,882,403.0	102,337,641.1	-47,455,238.1	-86.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,836,400.0	54,520,926.8	-14,684,526.8	-36.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.0	3,703,419.8	-2,703,419.8	-270.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	14,046,003.0	44,113,294.4	30,067,291.4	-214.1
VIII	Төсвийн тохируулга, зарлагын зөрүү		(55,862,627.8)		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН (I)	-	8,086,720.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	8,086,720.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,086,720.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,062,275.5
131105	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	24,444.5
2	НИЙТ ЗАРДАЛЫН ДҮН (II)	-	8,086,720.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	86,720.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	86,720.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,220.0
210404	Ном, хэвлэл	-	23,220.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	28,738.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	28,738.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34,762.0
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	34,762.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	8,000,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	-	8,000,000.0

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/21/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан болон харьяа байгууллагуудын сангаас олгосон жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээл байна.	25,304.8	Албан шаардлага Зөвлөмж, Акт	ХЭДС болон харьяа газрын дарга, нягтлан бодогч нар	
2	Анод банк, Капитал банк, Дэлгэр экспресс ХХК-с авах олон жил болсон, эрсдэлтэй авлагыг барагдуулаагүй байна.	2,413.1	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Т.Бадрахбаяр Б.Оюунбилэг
3	ХХҮЕГ-ын Хяналт мониторингийн газраас 4 дүүрэг, 8 аймгийн ХЭДС-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн боловч, нийт зээлийн авлагын үлдэгдлийн 51.8 хувийг эзэлж байгаа ХЭД төв сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Т.Бадрахбаяр Б.Оюунбилэг
4	ХБХХЕГ ХЭДС Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.4.4-т "эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулсны дараа төслүүдийг хүлээн авна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ц.Ганчимэг Ж.Хаш-эрдэнэ

5	ХБХХЕГ ХЭДС Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс гаргасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам, арга аргачлалыг батлаагүй байна.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ц.Ганчимэг Ж.Хаш-эрдэнэ
6	ХБХХЕГ ХЭДС "Цэгц медиа групп" ХХК гэрээний үүргээ биелүүлээгүй, 3.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй	3.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ц.Ганчимэг Ж.Хаш-эрдэнэ
7	Дэмжлэг авсан Аз сод ТББ, Ар амин хүсэл ХХК нь гэрээний үүргээ биелүүлж үйл ажиллагаагаа тайлагнаагүйгээс үлдэгдэл 30%-ийн дэмжлэгээ аваагүй	6.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ц.Ганчимэг Ж.Хаш-эрдэнэ
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ХЭДС-гийн үйл ажиллагаатай уялдаагүй. /ХНХСИнститут, Дархан, Дорноговь, Хөвсгөл, БЗД/	-	Зөвлөмж	Дархан, Дорноговь, Хөвсгөл, Баянзүрх дүүрэг	
9	Нийслэлийн ХЭГ тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй он дамжсан 13.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.	13.1	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Батхүлэг С.Болд
10	Нийслэлийн ХЭГ сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт шалгалт хангалтгүй	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Батхүлэг С.Болд
11	Нийслэлийн ХЭДС-ийн хөтөлбөрт хамрагдах нийтийг хамарсан ажилд зарцуулах зардлын 10-15 хувийг хог хаягдал цэвэрлэгээний ажилд зарцуулахаас 12.4 сая төгрөгийг илүү зарцуулсан	12.4	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Батхүлэг С.Болд
12	БНД-ийн ХЭДС авлагын дансны 655.9 сая төгрөгийн үлдэгдлийг харилцагч тус бүрээр кодолж санхүүгийн программд тусгаагүй.	655.9	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэннадмид Ш.Зулцэцэг
13	БГД ХЭДС санхүүгийн тайланд тусгасан хөтөлбөртэй холбоотой 657.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	657.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Батбаяр З.Ганцэцэг
14	БГД ХЭДС ЗГ-ын 2009 оны 26 (хуучин), 2019 оны 111 дүгээр тогтоолын дагуу хөдөлмөрийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутам төлөх төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллага, бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээдээс авч төвлөрүүлэхийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-д үүрэг болгосон ч энэ орлого бүрдүүлэх талаар судалгаа хийгээгүй, арга хэмжээ зохион байгуулаагүй.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Батбаяр З.Ганцэцэг

15	БЗД ХЭДС сангийн үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн 28.9 сая төгрөгийн ном, гарын авлага, сургалтын зардлууд баримтаар нотлогдохгүй байна	28.9	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Цолмонгэрэл Г.Нарангэрэл
16	БЗД-ийн ХЭДС сангаас ХХҮХ-т 1.1 сая төгрөгийн шатахууныг шилжүүлсэн гэж тайлагнасан боловч шатахууныг хүлээлгэж өгөөгүй байна.	1.1	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Цолмонгэрэл Г.Нарангэрэл
17	БЗД-ийн ХЭДС өмнөх оны аудитаар 842.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйд албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.	842.7	Сахилгын шийтгэл ноогдуулах	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Цолмонгэрэл Г.Нарангэрэл
18	БЗД-ийн ХЭДС аудитад шаардлагатай баримт материал, мэдээллийг шаардсан хугацаанд ирүүлээгүй зөрчилд албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.	239.6	Сахилгын шийтгэл ноогдуулах	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Цолмонгэрэл Г.Нарангэрэл
19	СБД-ийн ХЭДС олон нийтийг хамарсан ажилд зарим иргэн уг ажилд оролцсон эсэх нь тодорхойгүй, харьяаллын бус иргэнийг оролцуулж нийт 0.3 мянган төгрөгийн ажлын хөлсийг олгосон.	0.3	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгонтуяа Т.Оюунгэрэл
20	Баян-Өлгий аймгийн ХЭДС нийтийг хамарсан ажил, ахмадын зөвлөх үйлчилгээний хөлснөөс 1.8 сая төгрөгийн татварыг суутган ч татварт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй, хувь хүнээс худалдан авсан бараа, хяналтын урамшуулалд олгосон хөлснөөс 1.0 сая төгрөгийн татварыг суутгаагүй байна.	2.8	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Сьезхан Т.Фарида
21	Баян-Өлгий аймгийн ХЭДС сангийн хөрөнгөөр худалдан авсан 16.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХҮГ-т шилжүүлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	16.4	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Сьезхан Т.Фарида
22	Баянхонгор аймгийн ХЭДС нь Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгаас төсвөөс 2017, 2018 онд олгосн санхүүжилтийн 7.2 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр, төв сангийн дансанд төвлөрүүлсэн.	7.2	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Амарсанаа Д.Алтанцэцэг
23	Булган аймгийн ХЭДС шатахууны зарцуулалтыг тухайн үеийн зах зээлийн нэгжийн үнээс 2.8 сая	2.8	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Н.Батжаргал П.Ундармаа

	төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна.				
24	Говь-алтай аймгийн ХХҮГ-ын дарга нь хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн зөвлөлд ажиллан 0.3 сая төгрөгийн урамшуулал авсан.	0.3	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Мянганбуу Л.Удвал
25	Говь-алтай аймгийн ХЭДС санхүүгийн дэмжлэг олгох гэрээний үнийн дүнгээс 1.0 сая төгрөг илүү олгосон.	1.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Мянганбуу Л.Удвал
26	Говь-алтай аймгийн ХЭДС түрээсийн төлбөр төлсөн анхан шатны баримтгүй байхад 0.3 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлсэн.	0.3	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Мянганбуу Л.Удвал
27	Говь-алтай аймгийн ХЭДС зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний дагуу 50.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй дэмжлэгийг бэлэн мөнгөөр үзүүлсэн.	50.0	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Мянганбуу Л.Удвал
28	Дорноговь аймгийн ХЭДС төсвийн орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 91.5 хувиар давсан байна.	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэндмаа Т.Азаяа
29	Өвөрхангай аймгийн ХЭДС хувь хүний орлогын албан татварын 2.0 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн.	2.0	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Ундрах Б.Болд
30	Сүхбаатар аймгийн ХЭДС малжуулах арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг, туслалцааны зардлыг 7.5 сая төгрөгийг илүү зарцуулсан	7.5	Албан шаадлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах Э.Улаанхүүхэн
31	Сүхбаатар аймгийн ХЭДС Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан иргэдийн зээлийн батлан даагчийн барьцаа хөрөнгө хангалтгүй, мөн хамтран ажиллах гэрээний 2.5, 3.5 дахь заалтын дагуу сар бүр үйл ажиллагааны тайланг санхүүгийн баримтын хамт хүлээн авч, төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй	200.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах Э.Улаанхүүхэн
32	Сүхбаатар аймгийн ХЭДС орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан иргэдийн зээлийн батлан даагчийн барьцаа хөрөнгө хангалтгүй, мөн хамтран ажиллах гэрээний 2.5, 3.5 дахь заалтын дагуу сар бүр үйл ажиллагааны тайланг санхүүгийн баримтын хамт хүлээн авч, төслийн хэрэгжилтийн явц, үр дүн,	-	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах Э.Улаанхүүхэн

	санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй.				
33	Ховд аймгийн ХЭДС ажил хайгч ажилгүй иргэдийг чадавхжуулах сургалтад хамруулах иргэдийг сонгосон шалгуур үзүүлэлт тодорхойгүй, тухайн хөтөлбөрт тогтмол ажилтай хүн хамрагдаж 4.6 сая төгрөгийг илүү зарцуулсан, суралцагчдаас тайлан илтгэх хуудас авч үр дүнг тооцоогүй байна.	4.6	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл Б.Саранцэцэг
34	Ховд аймгийн ХЭДС сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, төсвөөс 40.9 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.	40.9	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл Б.Саранцэцэг
35	Ховд аймгийн ХЭДС залуучуудын гарааны бизнес дэмжих ажлын хэсэг нь зорилго нь тодорхойгүй төслийг сонгон шалгаруулсан, хурлын тэмдэглэл, протокол үйлдэж баримтжуулаагүй, төсөлд шалгарсан оролцогчдыг удирдлагаар баталгаажуулаагүй байна.		Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл Б.Саранцэцэг
36	Хөвсгөл аймгийн ХЭДС 1.8 сая төгрөгийн шатахуун, 2.2 сая төгрөгийн томилолтын мөнгө нийт 4.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг 2019 онд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	4.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрдэнэхуяг Б.Гантуяа
	Дүн	30,517.7			